

“Хуртай намар-2018” үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан ажлын тайлан

2018 оны 09 сарын 12-ны өдөр Дэлгэрцогт сумын “Хуртай намар-2018” үзэсгэлэн худалдаа удирдамжын дагуу амжилттай зохион байгуулагдлаа. Үзэсгэлэн худалдаагаар нийт 8 төрлийн номинацаар шилдгүүдээ шалгарууллаа. Үзэсгэлэн худалдаанд 1-р багийн 5 иргэн, 2-р багийн 4 иргэн, 3-р багийн 7 иргэн тус тус цагаан идээ, эсгий урлал, үндэсний хувцас, хүнсний ногоогоор оролцсон.



1. Сумын бренд бүтээгдэхүүнээр 3-р багийн иргэн Х.Дүүрэнцэцэгийн цагаан идээ
2. Борлуулалтаар тэргүүлсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр 2-р багийн иргэн А.Нямцэрэнгийн үндэсний хувцас
3. Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүнээр 2-р багийн иргэн А.Нарантуяагийн цагаан идээ
4. Шилдэг айраг үйлдвэрлэгчээр 1-р багийн иргэн Б.Ганзориг
5. Шилдэг өрхийн тариаланчаар 1-р багийн Ч.Доржпүрэв хүнсний ногоо
6. Шилдэг хоол үйлдвэрлэгчээр 3-р багийн иргэн Ц.Ганхүү
7. Шилдэг үндэсний хувцас үйлдвэрлэгчээр Ё.Энхбаяр
8. Шилдэг эсгий, ноосон эдлэлээр 3-р багийн иргэн Х.Ганпүрэв тус тус шалгарлаа.



Мөн тус үйл ажиллагааны үеэр “Ашиг шимт малын үзэсгэлэн худалдаа”-г зохион байгууллаа.

Шилдэг Хуц, ухна, эм хонь, эм ямааг шалгарууллаа. 5 хуц, 5 ухна, 7 эм ямаа, 5 эм хонь шалгаруулалтанд оролцлоо.

Шилдэг хуц: 1-р байр: 1-р багийн малчин Б.Доржготовын халзан хуц 86,8кг

2-р байр: 2-р багийн малчин Э.Дэлгэрбаярын шар халзан хуц 77кг

Шилдэг ухна: 1-р байр: 2-р багийн малчин Э.Дэлгэрбаярын халтар ухна 72кг

2-р байр: 1-р багийн малчин Д.Гаваагийн хар алаг 70кг

Шилдэг эм хонь: 1-р байр: 1-р багийн малчин Б.Аюушын шар нүдэн эм хонь 61,6кг

2-р байр: 1-р багийн малчин О.Нямбуугийн шар нүдэн эм хонь 60кг

Шилдэг эм ямаа: 1-р байр: 3-р багийн малчин Н.Гантулгын улаан бор ямаа 56кг

2-р байр: 1-р багийн малчин О.Нямбуугийн улаан ямаа 51кг тус тус шалгарлаа.

